



177

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 6 сарын 02 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Нийслэлийн Мал эмнэлгийн газар /Н.Лхагвасүрэн/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2003 оны 99 дүгээр захирамжийн 5 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2005 оны
 217-р тоот 6-р сарын 02-д өдрийн
 захирамжийн хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн мал эмнэлгийн газар / цаашид "газар" гэх / нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд малын халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээ, оношлогоо, баталгаажуулалт хийх, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага мөн.

1.2. Газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн албаны болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тогтоол, захирамж, шийдвэр, бусад холбогдох хууль тогтоомжууд энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.3. Газар нь Хүнс хөдөө аж ахуйн яамны мал эмнэлгийн газраас мэргэжил арга зүйгээр хангагдаж, Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч, тамгын газар, мэргэжлийн төв байгууллагад ажлаа тайлагнана.

1.4. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай, банкинд харилцах данстай байна.

1.5. Газрын бүтэц, орон тоог Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.6. Газрын дарга нь эрх зүйн асуудлаар тушаал гаргаж шийдвэрлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа ил тод шударга ёсны зарчим баримтална.

1.7. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлөх бөгөөд мэргэжилтнүүдтэй үр дүнгийн гэрээтэй ажиллаж, тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг батална.

1.8. Газрын орлогч даргыг Нийслэлийн засаг даргатай зөвшилцөж, газрын дарга томилж чөлөөлнө.

1.9. Газрын даргын дэргэд орон тооны бус зөвлөл ажиллаж, байгууллагын стратеги бодлого төлөвлөлт, зорилт, бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан, үр дүн, хэрэгжүүлэх ажил, хүний нөөцийн асуудлаар хамтын удирдлагын шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ./Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана. /

1.10. Газрын дарга нь төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 19-р зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлж, газрын төсвийг захиран зарцуулна.

1.11. Газрын дарга нь мал эмнэлгийн байгууллагын чадавхи, хүний нөөцийн асуудлыг бэхжүүлэх, ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх анхаарах

1.12. Бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, мэдээ, мэдээлэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлаар яам, агентлаг, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, бусад холбогдох газруудтай хууль эрх зүйн хэм хэмжээнд уялдуулан зохицуулна.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Монгол улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тухай бүр тайлагнах,

2.3. Мал эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний талаар Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулж мал эмнэлгийн хорио цээр хязгаарлалт тогтоох, малын халддварт өвчинтэй тэмцэх ажлыг мэргэжлийн төв байгууллагын шийдвэр, засаг даргын захирамжийн хүрээнд шийдвэрлэх,

2.4. Мал сүргийг халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг жил бүр төлөвлөн, Хүнс, хөдөө аж ахуйн яам, улсын мал эмнэлгийн газарт нэгдсэн захиалга өгч, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээтэй ажиллаж, төлөвлөгөөг биелүүлэх,

2.5. Малын гоц халдварт өвчин илэрсэн тохиолдолд дээд шатны байгууллагад мэдэгдэх, өвчний оношийг тогтоох, тархалтыг зогсоох, түүнийг устгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх,

2.6. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дэхь заалтыг үндэслэн малын халдварт өвчин гарсан үед хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээг орон нутгийн төр захиргааны болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран тогтоож, хэрэгжилтийг хангуулах.

2.7. Мал сүргийг эрүүлжүүлэх, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, хорио цээрийн талаар хэвлэл мэдээлэл, радио телевизээр сурталчилгаа явуулах ;

2.8. Нийслэлийн нутаг дэвсгэрт гарч байгаа мал, амьтны элдэв өвчнүүдийн гаралт, тархалт, хөдлөл зүйг бүртгэсэн иж бүрэн зураглал судалгаа хийх;

2.9. Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ;

2.10. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх заалтыг үндэслэн мал эмнэлгийн үйлчилгээнд шаардагдах эм биобэлдмэл, багаж төхөөрөмжийн захиалга хийх, тэдгээрийг татан авах, хадгалах, хуваарилах, зарцуулах, эмийн нөөц бий болгох асуудлыг зохион байгуулах;

2.11. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн мал эмнэлэг, үржлийн албаны ажил үйлчилгээтэй танилцаж, үүрэг даалгавар өгөх, ажлыг нь дүгнэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах , туслалцаа үзүүлэх ;

2.12. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн мал эмнэлэг, үржлийн алба, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн үйл ажиллагааны тайлан мэдээг улирал, жилээр авч, нэгтгэн дүгнэлт гаргах, мэргэжлийн төв байгууллагад мэдээлэх;

2.13. Нийслэлийн хэмжээнд мал эмнэлгийн ажил үйлчилгээнд шаардлагатай лабораторийн багаж хэрэгсэл, аппарат, тоног төхөөрөмж, эм урвалжийн хөрөнгө санхүүгийн асуудлыг Нийслэлийн засаг даргад танилцуулж, шийдвэрлүүлэх ;

2.14. Газрын лаборатори нь малын халдварт , паразит, халдваргүй өвчнийг оношлох, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг, экспорт, импортын үйл

ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шинжилгээ хийж, мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ олгох;

2.15. Дүүргийн мал эмнэлэг, худалдааны төв, түүхий эдийн зах, аж ахуйн нэгжийн дэргэдэх лабораториудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнд хийж байгаа үзлэг шинжилгээ, мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний үнэн зөв эсэхэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд Нийслэлийн мал эмнэлгийн лаборатори дээж авч шинжлэн улмаар Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид шинжилгээ хийлгэн, баталгаажуулах;

2.16. Өвчний онош батлуулах, тодруулах, маргаан шийдвэрлэх зорилгоор зохих журмын дагуу дээж авч, шинжлэх, гаргах, шаардлагатай гэж үзвэл баталгааг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын дүгнэлтийг дахин гаргуулах;

2.17. Мал эмнэлгийн боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх, шагнаж урамшуулах, тэтгэлэг тусламж үзүүлэх, туршлага судлуулах, гадаад улс орнуудын ижил төстэй мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, уялдаа холбоог бэхжүүлэх;

2.18. Газрын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах;

2.19. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ, тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах;

2.20. Малын өвчнийг оношлох, эмчлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, мал, амьтныг тогтоосон хугацаанд бүрэн хамруулах;

2.21. Мал, амьтныг эмчлэх, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, малын эм хангамжийн худалдаа, үйлчилгээ эрхлэх;

Гурав. Газрын эрх

3.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. дэх заалт, Хүнс хөдөө аж ахуйн яамны сайдын баталсан загвар, тодорхойлолтын дагуу мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээг нэгдсэн кодтой, тусгай нууцлалтай хэвлүүлэх, дугаарлах, дүүргийн мал эмнэлгийн

нэгжүүд болон хүнсний бөөний худалдааны төв, түүхий эдийн захын дэргэд ажиллаж байгаа мал эмнэлэг ариун цэврийн лабораториудад хуваарилан хүргүүлэх, хяналт тавих;

3.2.Орон нутгаас бэлтгэгдэн Улаан баатар хотын хүнсний зах, худалдааны төвүүд, нийтийн хоолны үйлчилгээний цэгүүдэд худалдаалагдаж байгаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг шинжилгээ хийж, мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ олгох,

3.3.Байгууллагын эд хөрөнгө, төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах ба барилга байгууламж, машин техник, тоног төхөөрмжийг засварлан сэлбэх, шинээр олох, барьж байгуулах, эдэлгээ ашиглалтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.4. Батлагдсан төсөв хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор өөрийн орлогын үйл ажиллагааны зардлаас уралдааны болзол зарлаж, дүгнэх

3.5.Мал , амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжилгээ хийж, экспортонд гаргах бүтээгдэхүүнд эцсийн баталгаажилт гарган, экспортын гадаад гэрчилгээ олгох ;

3.6.Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 4-ийн 7-г үндэслэн ажилчин, албан хаагчдаас шинэ орон сууц худалдан авах, нөхцлөө сайжруулах, амины сууц барих, газар эзэмших зэрэг асуудалд урт богино хугацааны хөнгөлөлттэй зээл олгох, мөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд туслах

3.7.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, зөвлөлгөө өгөх, дээд шатны байгууллагад уламжлах, асуудал боловсруулж шийдвэрлүүлэх;

3.8. Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй худалдаа, үйлчилгээний төв, мал , амьтны хашаа байр, тоног хэрэгсэл, хэвтэр бууц, устгалын цэг, бэлчээр зэргийг зохих нөхцлийг сайжруулах талаар арга зүйн зөвлөлгөө өгч, ажил сайжруулах талаар шаардах ;

3.9. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэр үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хүний эрүүл мэндэд хор хохирол учруулах, мал, амьтны халдварт өвчин тараах нь тогтоогдсон бол мэргэжлийн хяналтын байгууллагад уламжилж, холбогдох арга хэмжээг авахуулах;

3.10. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэр үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гарсан зөрчил дутагдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдэгдэх, сэрэмжлүүлэг өгөх, зохих заавар журмын дагуу халдваргүйжүүлэлт хийх;

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1. Газрын дарга, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү дүрмэнд Нийслэлийн засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

5.2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэж бүртгүүлнэ.